



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх ачит” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/229/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 11315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
“Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал:
С.Оюунгэрэл
Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13

№

861

танай

-ны №

-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЭНХ-АЧИТ ӨРХИЙН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Ж.ОТГОНЦЭНГЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх ачит” ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Энх ачит” ӨЭМТ нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх ачит” ӨЭМТ нь тайлант онд давхардсан тоогоор 26,361 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлснээр Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 336.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна. Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

1426050473

C:\Users\arangua\Desktop\Бичиг хэргийн хэргийн 2026\2026\word\ywan_bchig_dugnet_2026.docx

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Энх ачит” ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалаар бүтцийг 11 орон тоогоор баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	226,488.76	62,204.27
Дансны авлага	19,534,160.47	4,432,033.20
Бараа материал	21,046,509.65	23,673,797.15
Эргэлтийн хөрөнгийн дүн	40,807,158.88	28,168,034.62
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	77,390,216.51	70,867,615.27
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,390,216.51	70,867,615.27
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	118,197,375.39	99,035,649.89
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	5,945,000.00	460,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,945,000.00	460,000.00
Өр төлбөрийн нийт дүн	5,945,000.00	460,000.00
Эзэмшигчдийн өмч	37,063,849.00	37,063,849.00
Төрийн	37,029,849.00	37,029,849.00
Хувийн	34,000.00	34,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	160,796.00	160,796.00
Хуримтлагдсан ашиг	75,027,730.39	61,351,004.89
Эзэмшигчдийн өмчийн дүн	112,252,375.39	98,575,649.89
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	118,197,375.39	99,035,649.89

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлогын дүн		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
Нийт ашиг (алдагдал)		
Бусад орлого	404,477,223.30	341,618,323.36
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	353,352,474.85	355,295,048.86
Санхүүгийн зардал		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	51,124,748.45	-13,676,725.50
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	51,124,748.45	-13,676,725.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	51,124,748.45	-13,676,725.50

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	353,084,915.03	355,325,044.13
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	33,086,600.00	59,763,400.00
Татаас, санхүүжилтийн орлого	318,958,504.14	290,902,462.17
Бусад мөнгөн орлого	1,039,810.89	4,659,181.96
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	339,255,318.91	343,729,328.62
Ажиллагчдад төлсөн	205,694,831.00	221,452,505.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,776,549.03	59,878,019.13
Бараа материал худалдан авахад төлсөн	35,095,980.57	23,193,231.00
Ашиглалтын зардалд төлсөн	11,521,411.74	1,825,362.96
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	20,355,246.00	22,840,998.00
Даатгалын төлбөрт төлсөн	1,454,367.00	1,756,493.00
Бусад мөнгөн зарлага	11,356,933.57	12,782,719.53
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,829,596.12	11,595,715.51
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	15,061,700.00	11,760,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	13,721,700.00	11,760,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,340,000.00	
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-15,061,700.00	-11,760,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Мөнгөн зарлагын дүн	6,000.00	
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,000.00	
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-1,238,103.88	-164,284.49
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,464,592.64	226,488.76
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,488.76	62,204.27

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	37,059,849.00	-	160,796.00	-	-	23,902,981.94	61,123,626.94
Өмчид гарсан өөрчлөлт	4,000.00				-		
Тайлант үеийн ашиг						51,124,748.45	51,124,748.45
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	37,063,849.00	-	160,796.00	-	-	75,027,730.39	112,252,375.39
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						-	-
Залруулсан үлдэгдэл		-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт					-		-
Тайлант үеийн ашиг						-13,676,725.50	-13,676,725.50
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	37,063,849.00	-	160,796.00	-	-	61,351,004.89	98,575,649.89

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 47,478.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 59 ширхэг 47,478,468 төгрөгийн компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгүүлж, алдааг залруулсан.

Энэ нь НББОУС 16: Үндсэн хөрөнгө “ үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ... тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна.”, Сангийн сайдын 2017 оны А/361 дүгээр тушаалаар баталсан" Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-д...Компьютер, бусад хэрэгсэл-ийг ангилан бүртгэнэ" гэсэн заалтууд болон санхүүгийн тайлагналын “иж бүрэн”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 59 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгээгүй.	1	47,478.5			1	47,478.5	1	47,478.5				
Дүн	1	47,478.5			1	47,478.5	1	47,478.5				